МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ /ЭХНИЙ ХАГАС ЖИЛ/ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**Улаанбаатар хот**
**2025 он**

# Агуулга

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ.....2
ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....2
2.1. “АЛСЫН - ХАРАА 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт.....2
2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.....2
2.3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.....3
2.4. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт.....4
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....5
3.1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт.....5
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН, ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....5
4.1 Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хэрэгжилт.....5
4.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ.....6
ТАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ (ЗӨВЛӨМЖ).....7
5.1. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ (зөвлөмж).....8
ЗУРГАА. ХАВСРАЛТ..... 9

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 18 Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт, шинжилгээ - үнэлгээний ажлын зорилго нь байгууллагын бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төлөвлөлт, биелэлтийг хэрэгжүүлсэн байдал , шийдвэр үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийж бодит мэдээллээр хангах, үр нөлөөг үнэлэх,үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг байгууллагын үйл ажиллагаанд цаашид тусган ажиллахад оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, ”Байгууллагын үйл ажиллагаа ,үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгон Хөрөнгө оруулалт, худалдааны газраас 2025 онд хэрэгжүүлсэн “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг баримт бичгүүдийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, холбогдох хууль тогтоомж тогтоол шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлыг хамруулж хяналт-шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг үнэлсэн болно.

## ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 2.1. “АЛСЫН - ХАРАА 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Хөрөнгө оруулалт, худалдааны газрын чиг үүргийн хүрээнд 4.1.27, 4.1.29, 4.4.8, 4.4.9, заалтуудыг хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан байна.

**Үнэлгээний чанарын үзүүлэлт**

| **Хэрэгжилт гаргах нийт зүйл, заалтын тоо** | | 4 | **Биелэлт** |
|---|---|---|---|
| **“Үр дүнтэй” буюу 85-100%** | 95% | 4 | **-** |
| **“Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 60-84%** | - | - | **-** |
| **“Үр дүн хангалтгүй” буюу 30-59%** | - | - | **-** |
| **“Үр дүн гараагүй буюу” 0-29%** | - | - | **-** |
| **“Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.”** | - | - | **-** |
| **Үнэлгээний дундаж** | | | **95%** |

“Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хяналтад авсан 4 заалт тус бүрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт “үр дүнтэй” буюу **95%** -ийн биелэлттэйгээр дүгнэгдэж биелэлтийн дундаж **95%** хувьтай байна. (Хавсралт 1)

### 2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын чиг үүрэгтэй холбоотой Монгол Улсын 5 хуулийн 38 заалт, УИХ-ын 3 тогтоолын 3 заалт, Монгол Улсын Засгийн газрын 32 тогтоолын 47 заалт, Засгийн газрын 18 хуралдааны тэмдэглэлийн 18 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 3 заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалт, Монгол Улсын

Ерөнхий сайдын 2 албан даалгаврын 9 заалт, Монгол Улсын Шадар сайдын 1 тушаалын 1 заалт нийт 64 эрх зүйн актын 120 заалтын арга хэмжээний биелэлтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдалд хяналт -шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах байдлаар үнэлэгдэв. Үүнд:

| д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр | Тоо | Хяналтад авсан заалтын тоо | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Монгол улсын хууль | 5 | 38 | 99.2 % |
| 2 | Монгол Улсын Их Хурлын тогтоол | 3 | 3 | 93,3 % |
| 3 | Монгол Улсын Засгийн газрын тогтоол | 32 | 47 | 96 % |
| 4 | Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 18 | 18 | 92 % |
| 5 | Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар | 2 | 3 | 100 % |
| 6 | Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 100 % |
| 7 | Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар | 2 | 9 | 96 % |
| 8 | Монгол Улсын Шадар сайдын тушаал | 1 | 1 | 100 % |
| | **Дундаж үнэлгээ** | **64** | **120** | **97.0%** |

Дээрх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудын 101 заалт 100%-ийн буюу бүрэн хэрэгжсэн, 8 заалт 90% - ийн, 6 заалт 80% - ийн 5 заалт 70% - ийн хэрэгжилттэй байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, ”Байгууллагын үйл ажиллагаа ,үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын дагуу Үр дүнтэй буюу 85 дээш хэрэгжсэн 109 заалт, Үр дүн хүлээгдэж байгаа буюу 60-80% - ийн хэрэгжилттэй 11 заалт дүгнэгдэж, нийт **97.0** хувийн биелэлттэйгээр хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна. (Хавсралт 2)

### 2.3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д Хөрөнгө оруулалт, худалдааны газрын чиг үүрэгт хамаарах 2 зорилтыг хэрэгжүүлэх 3 арга хэмжээ тусгагдсан.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 зорилтыг хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хүрээнд Хөрөнгө Оруулалт Худалдааны газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрсэн түвшний тайлагналт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах байдлаар үнэлсэн. Үүнд:

Үнэлгээний чанарын үзүүлэлт

| **Хууль тогтоомж** | | Үр дүнтэй 85-100% | Үр дүн хүлээгдэж байгаа 60-84% | Үр дүн хангалтгүй 30-59% | Үр дүн гараагүй 0-29% | Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2 Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин | 3.2.2.2 | 90% | - | - | - | **-** |
| 4.4.2 Гадаад бодлого | 4.4.2.11 | - | 80% | - | - | **-** |
| | 4.4.2.13 | 90% | - | - | - | **-** |
| **Биелэлтийн дундаж** | | **87.0%** | | | | |

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2 зорилтыг хэрэгжүүлэх 3 арга хэмжээнээс “Үр дүнтэй” буюу 90 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, “Үр дүн хүлээгдэж байгаа ” буюу 80 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний биелэлтийн дундаж **87%** буюу үр дүнтэй гэж үнэлсэн байна. (Хавсралт 3)

## 2.4. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан Хөрөнгө оруулалт, худалдааны газрын үндсэн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх 2 зорилт 3 арга хэмжээг хяналтад авч ажилласан. Үүнд:

Үнэлгээний чанарын үзүүлэлт

| **Хууль тогтоомжууд** | | Бүгд | Үүнээс: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үр дүнтэй | Үр дүн хүлээгдэж байгаа | Үр дүн хангалтгүй | Үр дүн гараагүй | Хэрэгжих хугацаа болоогүй |
| Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт | | 3 | 1 | 2 | - | - | **-** |
| 1.4 Гадаад худалдааг хөнгөвчилнө. | 1.4.1.1 | | - | 80% | | | |
| 2.1 Хөрөнгө оруулалт хийх бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ. | 2.1.1.1 | | 100% | - | - | - | **-** |
| | 2.1.1.2 | - | - | 80% | - | - | **-** |
| **Гүйцэтгэлийн хувь** | | **86.7%** | | | | | |

Нийт хэрэгжилтээс зорилтот түвшиндээ хүрсэн “Үр дүнтэй” буюу 100 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, “Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 80 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байна. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан тус байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн дундаж **86.7** хувь байна. *(Хавсралт 4)*

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 3.1. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 4.2 дахь хэсэгт “Байгууллагын захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргах бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж эхний хагас жилд явцын хяналт-шинжилгээ, жилийн эцэст хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, ”Байгууллагын үйл ажиллагаа ,үр дүнг үнэлж дүгнэх журам”- д заасан аргачлалаар хийж гүйцэтгэв.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 6 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг тоймлон харуулъя. Үүнд:

| Д/д | Хэлтэс | Арга хэмжээ | Хэрэгжилт: | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үр дүнтэй | Үр дүн хүлээгдэж байгаа | Үр дүн хангалтгүй | Үр дүн гараагүй | Хэрэгжилт тооцохгүй |
| 1 | Хөрөнгө оруулалтыг дэмжих хэлтэс | 10 | 7 | 3 | - | - | - |
| 2 | Худалдааг дэмжих хэлтэс | 7 | 5 | 2 | - | - | - |
| 3 | Мэдээлэл харилцааны хэлтэс | 5 | 5 | - | - | - | - |
| 4 | Захиргаа, хууль, эрх зүйн хэлтэс | 9 | 8 | 1 | - | - | - |
| 5 | Дотоод хяналт, аудитын хэлтэс | 3 | 3 | - | - | - | - |
| **Нийт** | | **34** | **28** | **6** | **-** | **-** | **-** |

Үүнээс “Үр дүнтэй” буюу 85 -100 хувийн хэрэгжилттэй 28 арга хэмжээ, “Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 60 - 84 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 6 зорилт 34 арга хэмжээний биелэлт **89.7** хувь буюу “ **Үр дүнтэй**” гэж үнэлэв. *(Хавсралт 5)*

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН, ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

### 4.1 Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам” болон тус журмын хавсралтаар баталсан хавсралтад заасан 46 шалгуур үзүүлэлтээс Хөрөнгө Оруулалт Худалдааны газрын үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 9, хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлын 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдлын 7, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 1, бусад мэдээллийн ил тод,

нээлттэй байдлын 2, нийт 25 шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хөрөнгө Оруулалт Худалдааны газар нь үйл ажиллагааны, хүний нөөцийн, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт”-ийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, цаг үеийн мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх чиглэлээр тайлант хугацаанд Хөрөнгө оруулалт худалдааны газрын “Invest Mongolia”, “Хөрөнгө оруулалт худалдааны газар” page хуудас нийт 18 арга хэмжээний 30 зурган пост, 3 видео рийл, 1 видео заавар, www.investmongolia.mn, www.ita.gov.mn цахим хуудас тус бүрд 5 мэдээ нийтэлж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэн ажиллаж байна. Шилэн дансны тухай хууль,Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь оруулж , нээлттэй, ил тод байдлын самбарын мэдээллийг сар бүр тогтмол шинэчлэн ажилласан байна. Түүнчлэн төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх боломжийг бүрдүүлэн шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь цахимаар өгч, хүсэлт, өргөдөл материалыг цахимаар хүлээн аван ажилласан байна.

Хүний нөөцийн сул орон тооны зарыг журмын дагуу цахим хаяг, мэдээллийн самбарт нээлттэй байршуулж , сул орон тооны зарыг олон нийтийн сүлжээнд нээлттэй байршуулсан байна.

Үнэлгээний чанарын үзүүлэлт

| Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэдээллийн хүртээмжтэй байдал (0-30) | | Хугацаандаа нийтэлсэн байдал (0-30) | | Мэдээллийн бүрэн бүтэн байдал (0-30) | | Эх сурвалжийн тодорхой байдал (0-30) | | Хэрэгжилтийн хувь | |
| Шалгуур үзүүлэлт | | Тоо | Оноо | Тоо | Оноо | Тоо | Оноо | Тоо | Оноо | Тоо | Хувь |
| **1** | Чиг үүрэг үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 9 | 29,4 | 9 | 30 | 9 | 27,2 | 9 | 28,3 | 9 | **95,7** |
| **2** | Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 6 | 30 | 6 | 30 | 6 | 30 | 6 | 30 | 6 | **100** |
| **3** | Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх ил тод, нээлттэй байдал | 7 | 30 | 7 | 27,8 | 7 | 25,7 | 7 | 30 | 7 | **100** |
| **4** | Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал | 1 | 30 | 1 | 30 | 1 | 30 | 1 | 30 | 1 | **100** |
| **5** | Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | 2 | 27,5 | 2 | 27,5 | 2 | 27,5 | 2 | 30 | 2 | **93,7** |
| **Нийт дундаж** | | **25** | **29,4** | **25** | **29,0** | **25** | **28,0** | **25** | **29,7** | **25** | **96,8** |

Нийт 5 төрлийн мэдээллийн эх сурвалжийн ил тод, нээлттэй байдлын 25 үзүүлэлтийг 4 шалгууруар үнэлэхэд “Нээлттэй мэдээллийн ил тод, байдлын хэрэгжилт” **96,8** хувиар үнэлэгдсэн байна. (*Хавсралт 6*)

## 4.2 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2, Шилэн дансны нэгдсэн цахим хуудас /www.shilendans.gov.mn/-т Хөрөнгө оруулалт,

худалдааны газрын 2025 оны эхний хагас жилийн  мэдээлэл оруулсан байдалд хяналт хийсэн.

| Үр дүнгийн мэдээлэл | Мэдээлсэн тоо | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|
| Мэдээлэл хугацаандаа оруулсан | 66 | 38.6 |
| Хугацаа хоцорсон мэдээлэл | 2 | 1.2 |
| Ил тод болгоогүй /Мэдээлэл оруулж байгаа/ | 0 | 0.0 |
| Мэдээлэл оруулах хугацаа болсон | 68 | 39.8 |
| Мэдээлэл оруулах хугацаа болоогүй | 103 | 60.2 |
| Мэдээлэл хугацаандаа оруулсан /оруулах мэдээлэл байхгүй/ | 66 | 97.1 |
| Мэдээлэл хоцорч оруулсан /оруулах мэдээлэл байхгүй/ | 2 | 2.9 |
| Ил тод болгосон /араас нь хугацаандаа зассан/ | 0 | 0.0 |
| Ил тод болгосон /араас нь хоцорч зассан/ | 0 | 0.0 |
| Мэдээлэл оруулаагүй | 0 | 0.0 |
| **Нийт** | **171** | |
| **Гүйцэтгэлийн хувь** | | **97.1** |

2025 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансанд байршуулах нийт 171 мэдээллээс 68 мэдээллийг тайлагнана. Үүнээс 66 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. 2025 оны эхний хагас жилийн  байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилт **97.1** хувь буюу “Үр дүнтэй” хэрэгжсэн байна. (Хавсралт 7)

## ТАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, САНАЛ (ЗӨВЛӨМЖ)

ХОХГ-ын 2025 оны Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж,тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж нэгдсэн үнэлгээ **92.7** хувийн биелэлттэй, **“Үр дүнтэй”** гэж дүгнэсэн байна.

| Үзүүлэлт | | Хувь | Жин | Оноо |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ | 1. Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт | 95 | 0.6 | 4.25 |
| | 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 97 | | |
| | 3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 87 | | |
| | 4. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт | 86.7 | | |
| Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ | 1. Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 89.7 | 0.1 | |
| Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ | 1. Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хэрэгжилт | 96.8 | 0.3 | |
| | 2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ | 97.1 | | |
| **Ерөнхий үнэлгээ:** | | **92.7** | **1** | |

### 5.1. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ (зөвлөмж)

1.Биелэлтийг нэгтгэхдээ хүрсэн байх зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хэрэгжилт, үр дүнтэй тулгах, хэрэгжүүлсэн ажлыг бүрэн тайлагнасан байдлыг нягтлах, хэрэгжилтийн хувийг бодитой тооцох;

2.Төлөвлөлтөд бодитой, үр дүнд хүрэхүйц цөөн тооны арга хэмжээ төлөвлөж, үр дүнтэй тайлагнах;

3.Бодлогын баримт бичгийн тайланг үнэлэх журмыг судалж, журамд заасан үнэлгээний дагуу хэрэгжилтийг үнэн зөв үнэлж, хэрэгжилт удааширсан болон хангалтгүй хэрэгжиж буй шалтгааныг дурдаж байх;

4.Байгууллагын болон бусад хөндлөнгийн байгууллагын судалгааг үнэлгээнд ашиглаж байх;

5.Тайлант онд хэрэгжиж дууссан байх, эрчимжүүлэх шаардлагатай гэж тодорхойлсон арга хэмжээг хяналтад авч, 2025 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна.

Танилцсан:
Хөрөнгө Оруулалт Худалдааны газрын
дарга: /В.Энхбаатар/

Хянасан:
ДХАХ-ийн дарга: /Б.Батбаяр/

Үнэлсэн:
ДХАХ-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ
хариуцсан ахлах мэргэжилтэн: /Г.Энх-Амгалан/

## ЗУРГАА. ХАВСРАЛТ

Хавсралт 1. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт

Хавсралт 2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Хавсралт 3. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт

Хавсралт 4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хавсралт 5. Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хавсралт 6. Байгууллагын ил тод байдлын үнэлгээний хэрэгжилт

Хавсралт 7. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ